



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/13

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
шинээр олгох тухай

Зөвшөөрлийн тухай хууль 3.2 дугаар зүйлийн 1.1, 8.1 дүгээр зүйлийн 13.19 дэх, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийн дагуу Нова дент ХХК-д (РД:3139719) Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг Чандмань 4 гудамж 400 дугаар байр 1 тоот хаягт Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ “Шүдний оношилгоо, эмчилгээ, согог засал” чиглэлээр клиник эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, холбогдох хууль, дүрэм, клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS6673:2017, эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартуудыг хангаж ажиллахыг Нова дент ХХК-ний захирал (С.Баатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын ажлын алба, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (О.Найгалмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВА-ОЧИР



64201035